



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

Өндөржүүлсэн бэлэн байдлын
зэрэгт шилжүүлэх тухай


Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.3, 33.1.5 дахь заалт, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 04 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамжийн дагуу Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны штабыг зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны штабын дарга Г.Нандинжаргалд даалгасугай.

2. Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны штабаас баталсан Төлөвлөгөөний дагуу зохион байгуулж буй арга хэмжээнүүдийг нэгдсэн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлж, штабаас өгсөн үүргийг заасан хугацаанд биелүүлж, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллахыг Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны мэргэжлийн ангийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Г.Ганхүү/-д зөвшөөрсүгэй.

САЙД



Д.СУМЬЯАБАЗАР

С8 0078